

Батлав.
Нийслэлийн Нийтийн Биеийн
Тамир Спортын Хорооны дарга

..... Ж.Ганболд
1116128787 ул. 9077448

Батлав.
“Никель Декель” ХХК-ний
захирал

..... Б.Батболд
1116226856 5120454

ХЭВЛЭЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

20... оны ... сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Нийслэлийн Нийтийн Биеийн Тамир Спортын Хороо (цаашид захиалагч гэнэ) нөгөө талаас Никель Декель ХХК (цаашид гүйцэтгэгч гэнэ) нар дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Гүйцэтгэх ажлын нэр:

“Улаанбаатар марафон” ОУГ

№	Бүтээгдэхүүн	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бариа зүүлт	300	2000	600 000
2	Батламж	30 000	100	3 000 000
3	Плакат	500	800	400 000
4	Урилга	200	3 000	600 000
5	Малгай	1 200	5 000	6 000 000
6	Фудболк	1 200	8 000	9 600 000
7	Уут	1 200	1 000	1 200 000
8	Азын сугалаа	25 000	8	200 000
9	Стенд /хөлтэй/	6	34 000	204 000
10	Энгэрийн дугаар	35 000	300	10 500 000

Бүгд: 32 304 000₮

НЭГ. Захиалагчийн эрх, хүлээх үүрэг

- 1.1 Захиалагч нь хэвлэлийн эхийг шалган, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 1.2 Гарын үсэг зурж баталгаажуулсан эх нь хүчин төгөлдөр байна.
- 1.3 Хэвлэх ажлын нийт төлбөр болох 32,304,000 /Гучин хоёр сая гурван зуун дөрвөн мянган/ төгрөгийг хэвлэгдсэн бүтээгдэхүүнээ хүлээн авсны дараа Никель Декель ХХК-ийн Голомт банкны 1901011220 дансанд төлнө.
- 1.4 Захиалагч нь гэрээний биелэлтэд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардана.

- 1.5 Захиалагч нь хэвлэлийн бүтээгдэхүүний чанарыг шалган хүлээн авна. Чанарын шаардлага хангаагүй тохиолдолд Гүйцэтгэгч талд эргүүлэн өгч засуулж дахин хэвлүүлэн авна.
- 1.6 Зохиогчийн эрх (хэвлэн нийтлэх)-ийг захиалагч эзэмшинэ.

ХОЁР. Гүйцэтгэгчийн эрх, хүлээх үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь баталсан засварын дагуу зөвхөн бичгээр баталгаажсан эхийг хэвлэнэ. Баталгаажгаагүй эх хэвлэсэн тохиолдолд гарах хохирлыг гүйцэтгэгч тал хариуцна.
- 2.2 Гүйцэтгэгч байгууллага нь хэвлэлийн бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд чанарын өндөр түвшинд хэвлэж хүлээлгэн өгнө.
- 2.3 Гүйцэтгэгч нь захиалагчаас ажлын хөлсийг (1.3-т заасны дагуу) шаардах эрхтэй.
- 2.4 Тус компаний захиалсан материал болон мэдээлэл гадагш алдагдахгүй байх, ижил төстэй байгууллагад санаа өгөхгүй байх
- 2.5 Захиалсан материалын өнгө алдаагүй яг хүссэн өнгөөр гарах. Өнгө алдагдсан тохиолдолд гүйцэтгэгч тал дахин хэвлэх үүрэгтэй
- 2.4 Зохиогчийн эрх (хэвлэн нийтлэх)-ийг захиалагч эзэмшинэ.

ГУРАВ. Талууд харилцан хүлээх үүрэг

- 3.1 Гэрээнд заасан үүрэг, нөхцөлийг биелүүлээгүйгээс шалтгаалан аль нэг талаас гомдол гарвал талууд харилцан зөвшилцөж асуудлыг шийдэх үүрэгтэй бөгөөд ингэж үл чадвал хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 3.2 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, албан ёсоор баталгаажуулсан өдрөөс эхлэн хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж дуустал хүчин төгөлдөр байна.
- 3.3 Гэрээний хүчинтэй хугацаа нь 2018 оны 04 сарын 10 аас эхлэн 2018 оны 05 сарын 20-ны өдрөөр дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагчийг төлөөлж:

ННБТСХ-ны
Нийтийн биеийн тамирын
хөгжлийн хэлтсийн дарга

/А.Болдмаа/



Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Төр захиргааны 4-р байр, 7 давхар
Утас: 312785, 99178373

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, 26/1
Утас: 99776909